



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ

ХУУЛЬ, ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ АРГАЧЛАЛ



giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



Im Auftrag des:
Bundesministerium für
wirtschaftliche Zusammenarbeit
und Entwicklung



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2010 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 10.1.7-д заасныг үндэслэн, хуулийн төсөл боловсруулах ажлыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. "Хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандаж судлах аргачлал"-ыг 1 дүгээр хавсралт ёсоор, "Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал"-ыг 2 дугаар хавсралт ёсоор, "Хуулийн төслийн зардлыг тооцоолох аргачлал"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хуулийн төсөл боловсруулахдаа дээрх аргачлалын дагуу үр нөлөөг тооцох, уг аргачлалыг холбогдох байгууллагуудад хүргүүлэн аргазүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Хууль зүйн бодлогын газрын дарга /Ц.Цолмон/-д даалгасугай.



ДАРГА

БАЯСГАЛАН

2011 оны 4 сар

Хууль, Улс
журмын тухай
шинжилгээ, үнэлг

1. Хуулийн
баталсугай.

2. Хуулийн
нөлөөг тооцох, үр
зөвлөгөөгөөр хан
/Г.Бат-Өлзий/-д д

Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны
99 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

**ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
УРЬДЧИЛАН ТАНДАЖ СУДЛАХ
АРГАЧЛАЛ**

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ УРЬДЧИЛАН ТАНДАЖ СУДЛАХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл.

1.1. Хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандаж судлах /цаашид "урьдчилан тандан судлах" гэх/ аргачлалын зорилт нь аливаа асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлон, тухайн асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбаруудыг илрүүлж, тэдгээрийн эерэг болон сөрөг талуудыг харьцуулан судалж, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг шийдвэр гаргагчид санал болгоход оршино.

1.2. Урьдчилан тандаж судлах ажиллагааг дараахь зорилгоор хийнэ:

1.2.1. тухайн шийдвэрлэх гэж буй асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох;

1.2.2. тухайн нийгмийн харилцаанд оролцогчдын санал, бодлыг тогтоох;

1.2.3. зорилгод хүрэх боломжит арга замыг /хуулийн төслийн хувилбар/ илрүүлэх;

1.2.4. хуулийн төслийн хувилбарын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тогтоох;

1.2.5. хуулийн төслийн хувилбар нь тухайн асуудлыг шийдвэрлэж чадах эсэх, түүнийг хэрэгжүүлэхэд зардал гарах эсэх.

1.3. Урьдчилан тандаж судлах ажлыг дараахь үе шатаар хийнэ:

1.3.1. асуудалд дүн шинжилгээ хийх;

1.3.2. зорилгыг томъёолох;

1.3.3. тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, сонгох;

1.3.4. зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандаж судлах;

1.3.5. хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх, зөвлөмж боловсруулах.

Хоёр. Асуудалд дүн шинжилгээ хийх

2.1. Асуудалд дүн шинжилгээ хийх үе шат нь дараахь хэсгээс бүрдэнэ:

2.1.1. асуудлыг¹ тодорхойлж, нарийвчлан томъёолох;

2.1.2. тухайн асуудлаар эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг, хүмүүс, байгууллага бусад этгээдийг тодорхойлох;

2.1.3. тухайн асуудлын учир шалтгаан буюу яагаад энэ асуудал үүссэнийг гаргаж ирэх.

2.2. Асуудлыг тодорхойлж, түүнд дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд салбарын мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцах, тухайн асуудалд хамаарах этгээдийн дунд санал асуулга явуулах, судалгаа авах, холбогдох байгууллагаас статистик тоо баримт авах, өмнө нь хийгдсэн судалгааны материалыг үзэх зэргээр судалгаа хийнэ.

2.3. Тулгамдаж буй асуудал нь нийгмийн аль хэсэг, ямар хүрээг хамарч байгаа, хамрах хүрээний сүүлийн жилүүдэд өссөн, буурсан тооны үзүүлэлт зэрэг асуудлын цар хүрээг тогтооход шаардлагатай бүх мэдээллийг ашиглана.

Жишээ:

“Урьд нь хорих ял эдэлж байсан этгээд гэмт хэрэг давтан үйлдэх явдал их гарч байна. Энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна” гэсэн чиглэлийг шийдвэр гаргагчаас авлаа гэж бодъё.

Шийдвэрлэвэл зохих асуудал: “Урьд нь хорих ял эдэлж байсан этгээд гэмт хэрэг давтан үйлдэх явдал их байна. Үүнийг хэрхэн багасгах вэ?”

Асуудлын хамрах хүрээ: Дээрх тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд эхлээд асуудлын хүрээгээ тодорхойлно. Үүний тулд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас дараахь мэдээллийг авч болох юм:

¹Аливаа хууль тогтоомж, нийгмийн төсөл, хөтөлбөрийн үндсэн зорилго нь нийгэмд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд оршдог. Тиймээс “Асуудал” гэдгийг нийгэмд тулгарч буй шийдвэрлэвэл зохих асуудал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад бодлогын баримт бичигт туссан зорилтын хүрээнд ойлгох нь зохимжтой. Түүнчлэн шийдвэр гаргагчаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг энэ хүрээнд хамруулан ойлгож болно.

- хорих ял шийтгүүлсэн этгээдээс хэд нь суллагдсаныхаа дараа дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаа талаар сүүлийн 3-5 жилийн судалгаа, тэдгээрийн өссөн, буурсан тоон үзүүлэлт;
- давтан үйлдэж байгаа гэмт хэргийн төрөл. Тухайлбал, эхлээд ямар гэмт хэрэг үйлдсэн хүмүүс давтан гэмт хэрэгт холбогдож байна, г.м;
- хоригдож байх хугацаанд сургалт, хүмүүжлийн ажил явуулдаг эсэх, хэрэв явуулдаг бол ямар чиглэлээр;
- давтан гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдийн боловсрол, мэргэжил, ажил эрхлэлтийн байдлын судалгаа;
- давтан гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийн нас, гэр бүлийн байдал.

Энэ асуудлаар эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Гэмт хэрэг давтан үйлдэх асуудалд нийгмийн ямар хэсэг, бүлгийн эрх, ашиг сонирхол хөндөгдөж байгааг тодорхойлно. Жишээн дээр нийгмийн бүх гишүүд, тэр дундаа эмзэг бүлгийн хүмүүс, ялтны гэр бүл, хорих байгууллага, хорих ангийн ажилтнууд орж болох юм.

Учир шалтгаан: Ял шийтгүүлээд суллагдсан этгээд дахин гэмт хэрэг үйлдэхэд дараахь нөхцөл, шалтгаанууд нөлөөлж байна гэж үзэж байна:

Ядуурал

Архидалт

Ажилгүйдэл

Гэр бүлийн асуудал

Хувь хүний хүмүүжил

Нийгэмшүүлэх талаар төрөөс тавих анхаарал сул. г.м

Гурав. Зорилгыг томъёолох

3.1. Зорилгыг² аль болох тодорхой, хэмжих боломжтой томъёолно.

3.2. Зорилгыг тухайн шийдвэрлэх гэж буй асуудлаас хамааруулан ерөнхий³ /тодорхой бус/ болон тодорхой⁴ /нэг агуулгатай/ гэсэн 2 хэлбэрээр томъёолж болно.

3.3. Зорилгыг томъёолохдоо тухайн зохицуулалтын зорилго нь юу вэ, гол зорилго, гол зорилгыг дэмжих зорилтууд бий эсэх, зорилтыг тодорхой гаргаж тавих боломжтой эсэх, мөн зорилгыг ерөнхий байдлаар томъёолох хэрэгтэй юу зэргийг анхаарна.

²Зорилго, зорилгыг ихэвчлэн удирдлагын /улс төрийн бодлогын/ зүгээс тогтоож өгдөг.

³Тодорхой тоо, хувь хэмжээ заахгүйгээр “бууруулна”, “өсгөнө”, “багасгана” гэх мэтээр ерөнхий байдлаар томъёолохыг ойлгоно.

⁴ 40% бууруулна” гэх мэтээр тодорхой тоо, хувь хэмжээ зааж томъёолохыг ойлгоно.

Жишээ:

Дээрхи жишээн дээр зорилго нь ял эдэлсэн иргэдийг давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, давтан гэмт хэргийн тоог бууруулах явдал болно.

Энэ нь тодорхой байдлаар томъёологдсон, дотроо зорилтод хуваагдах шаардлагагүй, нэг агуулгатай зорилго болно.

Дөрөв. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, сонгох

4.1. Энэ үе шатанд томъёолсон зорилгыг биелүүлэхэд чиглэсэн, зохицуулалтын хувилбаруудыг гаргана. Зохицуулалтын дараахь хувилбарууд байна:

4.1.1. "тэг" хувилбар⁵ буюу ямар нэгэн зохицуулалтаас татгалзах;

4.1.2. хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хандсан ухуулга сурталчилгаа хийх;

4.1.3. зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулалт хийх;

4.1.4. төрөөс санхүүгийн интервенц хийх;

4.1.5. төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;

4.1.6. тогтоол, шийдвэр, дүрэм, журам гаргах. Үүнд хуулиас бусад эрх зүйн акт, тухайлбал УИХ, Засгийн газрын тогтоол, сайд, агентлагийн даргын тушаал, Засаг даргын шийдвэр хамаарна.

4.1.7. хуулийн төсөл боловсруулах⁶.

4.2. Зохицуулалтын хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон бусад

⁵Энэ байгаа хуулийн зохицуулалтыг хэвээр нь үлдээвэл яах вэ гэдгийг нягтална. Үүнд хэрэв тухайн асуудлыг өөр аргаар тууль тогтоомжоор огт зохицуулаагүй байгаа бол тэр хэвээр нь үлдээх буюу зохицуулалтаас татгалзах асуудал мөн хамаарна. Аливаа асуудлыг шийдвэрлэх арга замыг хайхдаа юуны өмнө дээрх хувилбараар шалгах нь зүйтэй.

⁶Хэвийнээр хууль нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх гол хэрэгсэл боловч тулгамдаж буй асуудал зөвхөн хууль гаргахнаар шийдвэрлэгдэнэ гэж ойлгож болохгүй юм. Ихэнх тохиолдолд аливаа асуудлыг шийдвэрлэх гарц нь мөн сайн тодорхойлсон нөхцөл бүхий хуулийн бус арга хэрэгслийг эрх зүйн зохицуулалттай хавсрах явдал байдаг.

дагалдан гарах үр нөлөөг ерөнхий байдлаар тандан судалж хамгийн боломжтой зохицуулалтын хувилбарыг сонгоно.

4.3. Аргачлалын 4.1.1-4.1.6-д дурьдсан зохицуулалтын хувилбарыг хэрэглэж зорилгод хүрэх боломжтой нь тогтоогдвол үр нөлөөг тандан судлах ажлыг цааш үргэлжлүүлэх шаардлагагүй бөгөөд энэ тухай дүгнэлт бичсэнээр ажиллагаа дуусгавар болно.

4.4. Асуудалд дүн шинжилгээ хийж, зохицуулалтын хувилбаруудыг сонгож, тандан судлах явцад тухайн асуудлыг зөвхөн хууль гаргах замаар шийдвэрлэнэ гэсэн дүгнэлтэд хүрвэл ямар бүтэц, агуулгатай хууль байх, ямар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай талаар ерөнхий байдлаар томъёолж бичнэ.

4.5. Дээр дурьдсан зохицуулалтын хувилбаруудаас бага зардлаар өндөр үр дүнд хүрэх зохицуулалтын хувилбарыг сонгоно.

4.6. Өргөн хүрээнд бодож томъёолсон дээрх хувилбаруудыг ерөнхий байдлаар тандан судлах явцад зарим хувилбар нь үр дүнгүй болох нь харагдаж болно. Өөрөөр хэлбэл, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхээр сонгож авсан зохицуулалтын хувилбарын талаар салбарын мэргэжилтнүүд, шинжээчид, тухайн зохицуулалтаар эрх ашиг, сонирхол нь хөндөгдөж буй этгээдтэй уулзалт, ярилцлага хийх зэрэг нэмэлт судалгаа хийсний дараа уг зохицуулалт үр дүнгүй гэдэг нь батлагдаж болно.

4.7. Аргачлалын 4.6-д заасан тохиолдолд үр дүнгүй гэсэн хувилбаруудаа орхиж, үр дүнтэй буюу цаашид үр нөлөөг нь тооцох шаардлагатай гэсэн хувилбаруудаа сонгон авч нарийвчлан томъёолно.

Жишээ:

- Ял эдлээд гарсан этгээд дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, давтан гэмт хэргийн тоог бууруулах асуудлыг судлах шатанд гаргаж ирсэн мэдээлэл, баримт дээрээ түшиглэн түүнийг шийдвэрлэх ямар ямар арга замууд байж болохыг томъёолно.
- Ингэхдээ хамгийн түрүүнд "Тэг" хувилбарыг шалгаж үзнэ. Жишээн дээр зохицуулалтгүй орхисон тохиолдолд тавьсан зорилгодоо хүрэх боломжгүй байна.

- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хичнээн хийгээд тэдгээр этгээдийг давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх магадлал маш бага.
- Түүнчлэн зах зээлийн хэрэгслийг ашиглах, төрөөс санхүүгийн интервенц хийх боломжгүй юм.
- Харин асуудалд дүн шинжилгээ хийсний дүнд тэдгээр этгээдийн дийлэнх нь мэргэжилгүй, шоронгоос гараад ажил олддоггүй, сэтгэл зүйн хувьд нийгэмд ажиллаж амьдрах бэлтгэлгүй байгаа нь дахин гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлдөг болохыг тогтоолоо гэж бодъё. Энэ тохиолдолд уг асуудлыг шийдвэрлэх арга зам нь хувийн хэвшлийнхэн, төрийн бус байгууллагатай хамтран мэргэжил олгох сургалт зохион байгуулж, ял эдэлж байх хугацаанд нь сэтгэл зүйн эмчилгээ хийх, ял эдэлж дууссаны дараа ажлын байраар хангах, мөн Эрүүгийн хуульд давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр өөрчлөлт оруулах зэрэг байж болох юм

Жишээ:

Ял эдлээд гарсан этгээд дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, давтан гэмт хэргийн тоог бууруулах асуудлыг шийдвэрлэх зорилгын хүрээнд:

1. Ялтанд ял эдэлж байх хугацаанд нь сэтгэл зүйн эмчилгээ хийх;
2. Ялтныг ял эдэлж дууссаны дараа ажлын байраар хангах талаар тодорхой арга хэмжээ авах;
3. Эрүүгийн хуульд давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялыг чангаруулах чиглэлээр өөрчлөлт оруулах зэрэг зохицуулалтын ерөнхий хувилбаруудыг илрүүлээ гэж бодъё.

Одоо харин эдгээр хувилбаруудаа дахин нягталж боломжтой хувилбарыг сонгоё. Үүний тулд аргачлалын 2.2 дахь хэсэгт заасны дагуу цуглуулсан мэдээлэл, тоо баримт болон холбогдох салбарын мэргэжилтнүүд, судлаачидтай илүү тодорхой асуудлаар ярилцлага хийх, тухайн асуудлаар эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүдээс судалгаа авах зэрэг туслах арга хэрэгслийг ашиглана.

1/ Судалгаагаар ялтан ял эдэлж дуусах үед нийгэмд ажиллаж амьдрах сэтгэл зүйн бэлтгэлгүй байдаг нь давтан гэмт хэрэг үйлдэх нэг шалтгаан болж байгаа нь тогтоогдлоо гэж үзье. Мөн ШШГЕГ-ын ажилтнууд болон одоо ял эдэлж байгаа ялтнуудтай уулзалт хийж, судалгаа авахад тэднийг нийгэмшүүлэх, сэтгэл санааны хувьд зөв чиглүүлж дэмжих ажиллагаа дутагдалтай байдаг

бөгөөд энэ талаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай гэсэн санал гарлаа гэж үзье. Энэ тохиолдолд 1 дүгээр хувилбарын үр нөлөөг тооцох ажиллагааг цааш үргэлжлүүлэх хэрэгтэй болно.

Үүний тулд эхлээд тухайн хувилбарынхаа нарийвчилсан томъёоллыг хийнэ.

Томъёолол: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтанд хорих ял эдэлж байх хугацаанд нь сэтгэл зүйн эмчилгээ болон сургалтыг тогтмол хийж байх талаар нэмэлт оруулна.

2/ Ялтныг ял эдэлж дууссаны дараа ажлын байраар хангах асуудлын тухайд өнөөдөр давтан гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдийн 60 орчим хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй байна гэж төсөөлье. Хэдийгээр тэд ял эдэлж байх хугацаандаа хорих байгууллагаас зохион байгуулсан техник мэргэжлийн сургалтад хамрагдаж, нийгэмд эрэлт хэрэгцээтэй мэргэжил эзэмшсэн байдаг боловч ажил олгогч ял эдэлж байсан этгээдийг ажилд авах сонирхолгүй байдгаас ажил эрхлэх боломжгүй байна. Иймд энэхүү асуудлыг төрөөс дэмжлэг үзүүлэх хэлбэрээр хуульчлан зохицуулах шаардлагатай гэж үзье.

Томъёолол: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд аж ахуйн нэгж нь хорих ял эдэлж суллагдсан этгээдийг авч ажиллуулбал эхний 2 жилд тухайн ажилчны сарын цалингийн 10 хувьтай тэнцэх хэмжээний дэмжлэгийг улсын төсвөөс олгох тухай нэмэлт оруулна.

3/ Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын хэмжээг чангаруулах чиглэлээр Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах хувилбарыг нягталж үзэхэд Эрүүгийн чиглэлийн хуулийн байгууллагын ажилтан, эрдэмтэн судлаачид давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын хэмжээг нэмэгдүүлснээр давтан гэмт хэрэг үйлдэхээс бүрэн хэмжээгээр урьдчилан сэргийлж, давтан гэмт хэргийн гаралтыг бууруулж чадахгүй гэсэн дүгнэлтэд хүрлээ гэж бодъё. Энэ тохиолдолд энэхүү хувилбарыг цааш үргэлжлүүлэх шаардлагагүй болно.

Ийнхүү сонгож авсан дээрх 3 хувилбарыг ерөнхий байдлаар нягталж шалгахад 3 дугаар хувилбар зорилгодоо хүрэхэд төдийлөн үр дүнтэй арга биш болох нь батлагдсан тул тэдгээрийн үр нөлөөг тооцох шаардлагагүй гэж үзлээ. Харин 1 болон 2 дугаар хувилбар нь давтан гэмт хэргийн гаралтыг бууруулахад илүү үр дүнтэй байх боломжтой байгаа тул томъёоллыг хийж үр нөлөөг тооцох ажиллагааг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Тав. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандаж судлах

5.1. Өмнөх үе шатанд сонгож авсан зохицуулалтын хувилбар бүрийн үр нөлөөг дараахь шалгуур үзүүлэлтийн дагуу тандаж судална:

- 5.1.1. зорилгод хүрэх байдал;
- 5.1.2. зардал, үр өгөөжийн харьцаа;
- 5.1.3. нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- 5.1.4. хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх.

5.2. "Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуурын хүрээнд тухайн зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр анх тавьсан/энэхүү аргачлалын дөрвөт заасны дагуу томъёолсон/ зорилгод хүрч чадах эсэхийг тогтооно. Ингэхдээ тухайн зохицуулалтын хувилбарыг өөр салбарт хэрэглэсэн ажилтгах туршлага байгаа эсэхийг судлах, уг асуудлаар эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд болон салбарын мэргэжилтнүүдийн санал, бодол зэргийг ярилцлага хийх, санал асуулга явуулах, өмнө хийгдсэн судалгааны материал ашиглах зэрэг ажиллагаа хийнэ.

Жишээ:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтанд хорих ял эдэлж байх хугацаанд нь сэтгэл зүйн эмчилгээ болон сургалтыг тогтмол хийж байх талаар нэмэлт оруулах жишээн дээр зорилгод хүрэх байдлыг давтан гэмт хэргийн тоо буурах эсэхээр шалгана. Ялтан хорих ял эдэлж байх хугацаандаа сэтгэл зүйн эмчилгээ тогтмол хийлгэж энэ чиглэлийн сургалтад хамрагдсанаар зөв дадал, хүмүүжлийг олохын хамт цаашид нийгэмд ажиллаж, амьдрах сэтгэл зүйн бэлтгэлтэй болно. Ингэснээр ялтан суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж, давтан гэмт хэргийн тоог бууруулах боломжтой гэж үзье.

Давтан гэмт хэргийн тоо буурах эсэхийг тогтоох нь ирээдүйд болох үйл явдлыг урьдчилан таамаглаж байгаа гэдгээрээ хүндрэлтэй, яг тодорхой гаргаж ирэх боломжгүй тул шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнууд, салбарын бусад мэргэжилтнүүдтэй уулзалт, ярилцлага хийж, тэдний санал, дүгнэлтийг сонсох замаар зорилгод хүрэх байдлыг тогтооно.

5.3. "Зардал, үр өгөөжийн харьцаа" гэсэн шалгуурын хүрээнд тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсвөөс зардал гарах үү, аж ахуйн нэгж, иргэдэд захиргааны ачаалал, зардал үүсгэх үү гэдгийг

ерөнхий байдлаар тандан судалж, зардал их/бага гарна, эсхүл зардал гарахгүй гэж хариулна.

5.3.1. тухайн хуулийн төслийг батлуулснаар нийгэмд ямар үр өгөөж үзүүлэхийг ерөнхий байдлаар гаргах хэрэгтэй. Хэдийгээр зардал их гарсан ч хуулийг хэрэгжүүлснээр нийгэмд эерэг үр өгөөж их байхаар бол тухайн төслийг үр ашигтай гэж үзэн, энэ тухай тайлбарлаж, дүгнэлтдээ оруулна.

5.3.2. харин зардал их шаардсан мөртлөө үр өгөөж бага байх төсөөлөл гарвал уг хувилбар үр ашиг муутай гэсэн дүгнэлтийг хийж болно.

5.3.3. шаардлагатай бол судалж байгаа асуудал, хуулийн төслийн онцлогоос хамаарч зардлыг "Хуулийн төслийн зардлыг тооцоолох аргачлал"-ын дагуу нарийвчлан тооцоолж болно.

Жишээ:

Хорих байгууллага бүрт сэтгэл зүйч эмч ажиллуулснаар улсын төсвийн ачаалал тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ. Гэвч хорих ял шийтгүүлсэн этгээд давтан гэмт хэрэг үйлдэх явдлыг бууруулснаар хувь хүн, гэр бүл, цаашлаад нийгэмд илүү их эерэг үр өгөөжтэй байхаар төсөөлөгдөж байна.

Энэ жишээн дээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хорих байгууллагын тоон дээр тулгуурлан шаардлагатай эмчийн тоог гаргаж, тэдгээрт хэдий хэмжээний цалин, бусад нэмэгдэл шаардагдахыг багцаалан тооцоолж болох юм.

5.4. "Нийгэм/хүйсийн тэгш байдал/, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө" гэсэн шалгуурын хүрээнд тухайн зохицуулалтын хувилбарын нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандаж судлана.

5.4.1. хуулийн төслийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судлахдаа дор дурдсан суурь асуултуудыг ашиглаж болно. /Хүснэгт 1, 2, 3-д харуулав./

Хүснэгт 1

ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	
		Тийм	Үгүй
Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	Хуулийн төсөл нь дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх үү (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	Хуулийн төсөл нь хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь зах зээлд шинээр монополийг бий болгох уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ УРЬДЧИЛАН ТАНДАЖ СУДЛАХ АРГАЧЛАЛ

Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	Хуулийг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжүүдэд тухайн хуулийг дагаж мөрдөхтэй холбогдон шинээр зардал үүсэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үйлдвэрлэлийн үндсэн хүчин зүйлсийг (түүхий эд, тоног төхөөрөмж, эрчим хүч, ажиллах хүч) гэх мэт хүчин зүйлс шинээр бий болгохыг шаардаж байгаа юу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Бараа, бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавьж байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Тухайн зохицуулалт нь аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэж байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Ижил тэнцүү нөхцөлд буй аж ахуйн нэгж, эсвэл бараа бүтээгдэхүүний хувьд харилцан адилгүй зохицуулалт бий болгож байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Мэдээлэх үүргийн улмаас үүсч буй захиргааны зардлын ачаалал	Хуулийн төслөөр хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардлуудыг (Жишээ нь, мэдээлэх, тайлан гаргах гэх мэт) бий болгож байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Дээрх зардлын ачаалал нь ялангуяа жижиг, дунд үйлдвэрүүдэд, эсхүл аж ахуйн нэгжийн тодорхой салбаруудад хүчтэй нөлөөлөхөөр байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ УРЬДЧИЛАН ТАНДАЖ СУЛЛАХ АРГАЧЛАЛ

Үгүй <input type="checkbox"/>	Өмчлөх эрх	Хуулийн төсөлд (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) өмчлөх эрхийг хөндсөн зохицуулалтууд орж байгаа юу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Үгүй <input type="checkbox"/>		Тухайн зохицуулалтаар өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгож байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Үгүй <input type="checkbox"/>		Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг зөрчсөн зохицуулалт орсон уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Үгүй <input type="checkbox"/>	Инноваци ба судалгаа шинжилгээ	Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг хуулийн төслөөр дэмжиж байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Үгүй <input type="checkbox"/>		Хуулийн төсөл нь үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгож байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Үгүй <input type="checkbox"/>		Нөөц боломжийг илүү үр дүнтэй ашиглахыг дэмжиж байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Үгүй <input type="checkbox"/>				
Үгүй <input type="checkbox"/>				

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ УРЬДЧИЛАН ТАНДАЖ СУДЛАХ АРГАЧЛАЛ

Хэрэглэгч ба гэр бүлийн төсөв	Хуулийн төслөөр хэрэглээний үнийн төвшинд нөлөө үзүүлж байгаа юу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгож байгаа юу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь бараа, үйлчилгээний хангамж болон чанарт нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлж байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь хувь хүний /гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд, мөн урт хугацааны туршид), эсвэл гэр бүл, үр хүүхдүүдийн эдийн засгийн баталгаатай байдалд нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тодорхой бүс нутаг, салбарууд	Хуулийн төсөл нь тодорхой бүс нутгуудад тодорхой нэг чиглэлд, ажлын байрыг шинээр бий болгох уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь тодорхой бүс нутгуудад тодорхой нэг чиглэлд, ажлын байрыг багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь жижиг, дунд үйлдвэрүүд, эсхүл аж ахуйн нэгжийн тодорхой салбаруудад онцгой нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Төрийн захиргааны байгууллага	Хуулийн төсөл нь улсын төсөвт нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийн төслийн дагуу шинээр төрийн байгууллага байгуулах, эсвэл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх шаардлага тавигдаж байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Төрийн байгууллагуудад захиргааны шинэ чиг үүрэг бий болж байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

ий үнийн а юу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
дын зах олгож	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
лгэний зүүлэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
ийн эрх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
ий /гэр (шууд, зэл гэр асгийн зүүлэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
бүс лэлд, х уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
бүс элд, лээр	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
унд ийн лөө	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
өө	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
йн йн лт на	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
ы	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

Макро эдийн засгийн хүрээнд	Хуулийн төсөл нь эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжиж байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Олон улсын харилцаа	Хуулийн төслийн зохицуулалтын улмаас инфляци нэмэгдэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь Монгол Улсын худалдааны бодлого, түүнчлэн олон улсын болон ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэгт нь сөрөг нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

Хүснэгт 2

НИЙГМИЙН ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	
		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	Хуулийн төслийн үр дүнд шинээр ажлын байр бий болох уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь ажлын байрны цомхотголыг шууд болон шууд бусаар бий болгох уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Тодорхой нэг ажил мэргэжлийн хүмүүст, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Ажиллах хүчин нэмж шаардагдах уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хөдөлмөрийн зах зээлд нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ УРЬДЧИЛАН ТАНДАЖ СУЛЛАХ АРГАЧЛАЛ

Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	Ажлын чанар, стандартад нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Ажилчдын эрх үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Шинээр ажлын стандарт гаргаж ирэх эсэх?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлтийг бий болгох эсэх?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	Хөдөлмөрийн зах зээлд ямар нэгэн өөрчлөлт оруулах уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх үү? Жишээ нь ядуу хүмүүс, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүйчүүдэд, үндэстний цөөнхөд г.м	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Хүйсийн тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх	Хуулийн төсөл нь ялгаварлан гадуурхахгүй байх, бүх хүнд ижил тэгш үйлчлэх, ижил боломж олгох зарчимтай нийцэж байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдэд ялгаатай нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хүйсийн тэгш байдлыг хангахад дэмжлэг үзүүлж чадах уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

Хувь хүн, гэр бүл, тэдгээртэй холбогдох мэдээлэл	Хуулийн төсөл нь захиргааны нэмэлт үүрэг, хариуцлага бий болгож байна уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хувийн нууцад /гэр бүлийн болон харилцаа холбооны/ нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Иргэдийн хувийн эрх, эрх чөлөөнд нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Гэр бүлийн амьдрал, гэр бүлийн хууль, эдийн засаг, нийгмийн хамгаалалтад нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хүүхдийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хувь хүний тухай мэдээлэл, түүнийг авахтай холбогдсон асуудалд нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>
Харилцаанд оролцогчдод ижил тэгш байдлыг олгож байна уу?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Соёлын болон хэлний ялгааг бий болгох уу?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх үү?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх үү?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх үү?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Улс төрийн намууд, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх үү?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Мэдээллийн эрх, эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрхэд сөрөг нөлөө үзүүлэх үү?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	Хувь хүний/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөлөөний улмаас эрүүл мэндэд гарах өөрчлөлт өсөх үү, буурах уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийн төслийн улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийн төсөл нь хүмүүсийн амьдралын хэв маяг /хооллолт, хөдөлгөөн, архи тамхины хэрэглээ/-т нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Нийгмийн тодорхой бүлэгт онцгойлон нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	Үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Иргэдийн боловсрол /төрийн болон хувийн хэвшлийн сургуулиар/ олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад сөрөг нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Их дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	Зохицуулалт нь нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

Соёл	Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Хэл соёлын ялгаатай байдалд нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

Хүснэгт 3

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	
		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Агаар	Хуулийн төслийн зохицуулалтын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Зам тээвэр, түлш эрчим хүч	Зохицуулалт нь тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/ бууруулах эсэх?	Тийм <input type="checkbox"/>
Эдийн засаг дахь эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх үү?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх үү?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх үү?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Ан амьтан, ургамлыг хамгаалах	Ан амьтны тоо хэмжээг бууруулах уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Усны нөөц	Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Усны бохирдлыг нэмэгдүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Ундны усны чанарт нөлөөлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

Хөрсний бохирдол	Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Зохицуулалт нь хөрсийг эвдлэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Газрын ашиглалт	Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Газрын зориулалтыг өөрчлөх эсэх?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй баялаг	Самар, жимс зэрэг нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг түүний нөхөн сэргээлтийн хугацаанаас өмнө ашиглах уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
	Нөхөн сэргээгдэхгүй баялгийг ихэсгэх үү?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

5.4.2. гэхдээ зөвхөн эдгээр асуултаар хязгаарлалгүй судалж байгаа асуудлын онцлогоос хамааран өөр өөр асуулт гаргаж ирэх хэрэгтэй. Асуултуудад аль болох ерөнхий байдлаар "тийм", "үгүй" гэж хариулна.

5.4.3. хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандаж судлах ажиллагааны хүрээнд тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх явцад урьдчилан тооцох боломжгүй сөрөг үр дагавар гарах эсэхийг тогтооно. Өөрөөр хэлбэл асуултуудад хариулах явцад ноцтой сөрөг үр нөлөө гарахаар байвал түүнийг гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

5.5. "Хуульд нийцэж байгаа байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараахь асуудлыг судлан үзнэ:

5.5.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцэж байгаа эсэх /авилгал, хүнд суртлыг үүсгэж байна уу, хүний эрх, эрх чөлөө, өмчлөх эрхийг хязгаарласан буюу хязгаарлахад чиглэсэн зохицуулалтыг агуулж байна уу/;

5.5.2. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын бусад улстай байгуулсан олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх.

5.6. Хувилбаруудын үр нөлөөг тандаж судлах ажиллагааны үед хэдийгээр шалгуур үзүүлэлтэд шууд хамаарахгүй ч тухайн зохицуулалтаар хэний ашиг сонирхол, ямар байдлаар хөндөгдөхийг тогтооно.

Жишээ:

Хувилбар хялбар болгс урьдчилан т ажлын зориг үзүүлэлтийг г

Зохицуулалтын хувилбар

Зс ху

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтанд хорих ял эдэлж байх хугацаанд нь сэтгэл зүйн эмчилгээ болон сургалтыг тогтмол хийж байх талаар нэмэлт оруулна.

Ялт ял : хугацаа сэтгэл эмч тогт хийг чигл сурт хамд хамд зөө д хууль олох цааш нийгд амьд зүйн болон Ингэс ялтан султан дахин хэрэг ч урьдч сартий давтан тоог бу боломж үзэж ба Зорилт байдлы гэмт хэр тоо буур эсэхээр шалгана.

Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>

Тийм судалж байгаа аж ирэх хэрэгтэй. "Тийм" гэж хариулна.

Тийм тандаж судлах гэж явцад урьдчилан тогтооно. Өөрөөр үр нөлөө гарахаар үзүүлэлтийн хүрээнд

Тийм нийцэж байгаа эсэх чөлөө, өмчлөх эрхийг туг агуулж байна уу/;

Тийм эрээ, конвенц, Монгол Тийм нийцэж байгаа эсэх.

Тийм дах ажиллагааны үед тухайн зохицуулалтаар Тийм тогтооно.

Жишээ:

Хувилбаруудын үр нөлөөг тандан судлах ажиллагааг ойлгомжтой, харьцуулахад хялбар болгохын тулд зохицуулалтын хувилбарын үр нөлөөг шалгуур үзүүлэлтээр урьдчилан тооцох ажиллагааг дор дурьдсан хүснэгтэд үзүүлэв. Судалгааны ажлын зорилго, зохицуулалтын хувилбарын онцлогоос хамааран өөр шалгуур үзүүлэлтийг гарган ирэх боломжтойг анхаарна уу.

Зохицуулалтын хувилбар	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ					Тухайн зохицуулалтаар эрх ашиг, сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох
	Зорилгод хүрэх байдал	Нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Зардал үр өгөөжийн харьцаа	Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлэх	Хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх	
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтанд хорих ял эдэлж байх хугацаанд нь сэтгэл зүйн эмчилгээ болон сургалтыг тогтмол хийж байх талаар нэмэлт оруулна.	Ялтан хорих ял эдэлж байх хугацаандаа сэтгэл зүйн эмчилгээ тогтмол хийлгэж энэ чиглэлийн сургалтад хамрагдсанаар зөв дадал, хүмүүжлийг олохын хамт цаашид нийгэмд ажиллаж, амьдрах сэтгэл зүйн бэлтгэлтэй болно. Ингэснээр ялтан суллагад дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж, давтан гэмт тоог бууруулах боломжтой гэж үзэж байна. Зорилгод хүрэх байдлыг давтан гэмт хэргийн тоо буурсан эсэхээр шалгана.	Давтан гэмт хэргийн гаралт буурна. Харин хорих байгууллага бүрт хоригдож байгаа ялтын тооноос хамааруулан сэтгэл зүйн эмч ажиллуулах тул улсын төсвийн ачаалал нэмэгдэнэ.	Хорих байгууллага бүрт сэтгэл зүйн эмч ажиллуулснаар улсын төсвийн ачаалал тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ. Гэвч хорих ял шийтгүүлсэн этгээд давтан гэмт хэрэг үйлдэх явдлыг бууруулснаар хувь хүн, гэр бүл, цаашлаад нийгэмд илүү их эерэг үр өгөөжтэй байхаар төсөөлөгдөж байна.	Байхгүй.	Нийцэж байгаа.	Хорих ял эдэлж байгаа ялтан, хорих байгууллагад ажиллаж байгаа сэтгэл зүйн эмч, Шүүхийн гийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан

<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд аж ахуйн нэгж нь хорих ял эдэлж суллагдсан этгээдийг авч ажиллуулбал эхний 2 жилд тухайн ажилчны сарын цалингийн 10 хувьтай тэнцэх хэмжээний дэмжлэгийг улсын төсвөөс олгох тухай нэмэлт оруулна.</p>	<p>Ял эдэлж гарсан этгээдийг ажлын байраар хангаснаар давтан гэмт хэргийн тоог бууруулах зорилго биелэх боломжтой гэж үзэж байна. Зорилгод хүрэх байдлыг давтан гэмт хэргийн тоо буурсан эсэхээр шалгана.</p>	<p>Нийгэмд ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, давтан гэмт хэргийн гаралтыг бууруулна. Улсын төсвийн орлого бага зэрэг буурна.</p>	<p>Аж ахуй нэгж болон улсын төсвөөс нэмэлт зардал гарахгүй. Харин ажил эрхлэлт нэмэгдэж, давтан гэмт хэргийн тоо буурна. Нөгөө талаас ажиллах хүч дутагдалтай байгаа салбарууд мэргэжилтэй ажилчнаар тодорхой хэмжээнд хангагдана.</p>	<p>Ял эдэлж байсан этгээдийг ажиллуулж байгаа хамт олны дунд сэтгэл зүйн таагүй байдал үүсэх магадлалтай.</p>	<p>Нийцэж байгаа</p>	<p>Аж ахуй нэгж, хамт олон болон ял эдлээд суллагдсан этгээд</p>
---	---	--	--	---	----------------------	--

Зургаа. Дүгнэлт, зөвлөмж боловсруулах

6.1. Хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандаж судалсны үр дүнд илрүүлсэн зохицуулалтын хувилбар тус бүрийн зэрэг болон сөрөг үр нөлөөг хооронд нь харьцуулж, дүгнэлт⁷ хийнэ.

6.2. Харьцуулсан дүгнэлтэд үндэслэн зөвлөмж бичнэ. Энэхүү зөвлөмжид илрүүлсэн хувилбаруудыг шат дараалан хэрэгжүүлэх, эсхүл тухайлсан 2 хувилбарыг хамтад нь хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй байж болох тухай, тулгамдаж буй асуудлыг зөвхөн хууль, эрх зүйн акт гарган шийдвэрлэхээс гадна түүнийг хуулийн бус аргатай хавсран хэрэглэвэл илүү үр дүнтэй байж болох тухай, мөн хамгийн оновчтой гэсэн ганц хувилбарын талаар бичнэ.



⁷Үр нөлөөг тандан судлах ажлын үр дүнд зарим тохиолдолд нэг хувилбараар зорилгод хүрэх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрч болно. Гэвч ихэнхдээ асуудлыг шийдвэрлэх хэд хэдэн боломжит хувилбарыг гаргаж ирдэг. тухайлбал 2 хувилбар хоёулаа хэрэгтэй гэвэл тэдгээрийг хооронд нь харьцуулах шаардлагагүй.

Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны
99 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Аж ахуй нэгж,
хамт олон
болон ял эдлээд
суллагдсан
этгээд

далсны үр дүнд
олон сөрөг үр

эхүү зөвлөмжид
сүл тухайлсан 2
ж болох тухай,
шийдвэрлэхээс
илүү үр дүнтэй
илбарын талаар

хүрэх боломжтой гэсэн
вилбарыг гаргаж ирдэг,
агагүй.

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалын зорилт нь боловсруулж буй хуулийн төслийн үр нөлөөг тооцож, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

1.2. Хуулийн төслийн үр нөлөөг тооцох /цаашид үр нөлөөг тооцох/ ажиллагааг дараахь зорилгоор хийнэ:

1.2.1. хуулийн төсөл, түүний зарим зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх;

1.2.2. хуулийн төслийг бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, заалтыг практикт туршиж үзэх;

1.2.3. хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоон түүнийг арилгах, хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр урьдчилан тооцоогүй үр дагавар /дагалдах үр дагавар/ гарах эсэхийг илрүүлэх;

1.2.4. хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр ямар үр нөлөө гарахыг тооцож, шаардлагатай бол тухайн хуулийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтыг дахин боловсруулах.

1.3. Үр нөлөөг тооцох ажиллагааг дараахь үе шатаар хийнэ:

1.3.1. шалгуур үзүүлэлтийг сонгох;

1.3.2. хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;

1.3.3. урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;

1.3.4. үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

АРГАЧЛАЛ

лын зорилт нь
хуулийн төслийн
ыг ойлгомжтой,
хуулийн төслийн

нөлөөг тооцох/

доторхой шалгуур

им зүйл, заалтыг

тогтоон түүнийг
тан тооцоогүй үр

үр нөлөө гарахыг
үл түүний зарим

хийнэ:

огтоох;

тохирох шалгах

Жишээ:

Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх, өмгөөллийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар судалгаа хийсэн. Судалгаанаас үзэхэд иргэд өмгөөлөгчдийг шүүхийн шийдвэрт нөлөөлж чаддаггүй, мэдлэг, ур чадвар муугаас гадна ёс зүйн тал дээр ихээхэн доголдолтой, өмгөөллийн үйлчилгээний хөлс хэт өндөр учраас өмгөөлүүлэх эрхээ эдэлж чаддаггүй гэх мэтээр өмгөөлөгчдийн байр суурь, эрх хэмжээний талаар хангалтгүй дүгнэлт өгсөн байна. Иймд өмгөөлөгчдийн холбоо болон өмгөөлөгчдийн бие даасан, хараат бус байдлыг хангах, өмгөөлөгчдийн мэргэжлийн ур чадвар, үүрэг, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх зэрэг чиглэлээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хууль санаачлагчаас уг хуулийн төслийн үр нөлөөг тооцох үүргийг өгсөн гэж үзье. Одоо хуулийн төслийн үр нөлөөг тооцоё.

Хоёр. Шалгуур үзүүлэлтийг сонгох

2.1. Энэхүү үе шатанд хуулийн төслийн /эсхүл түүний тодорхой хэсгийн/ үр нөлөөг тооцох шалгуур үзүүлэлтийг тогтооно.

2.2. Хуулийн төслийн үр нөлөөг тооцох дараахь үндсэн шалгуур үзүүлэлт байна:

- 2.2.1. зорилгод хүрэх байдал;
- 2.2.2. практикт хэрэгжих боломж;
- 2.2.3. ойлгомжтой байдал;
- 2.2.4. хүлээн зөвшөөрөгдөх байдал;
- 2.2.5. зардал;
- 2.2.6. харилцан уялдаа.

2.3. "Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр хуулийн төслийг боловсруулах болсон үндэстэл, тухайн хуулийн төслөөр тавьж буй зорилгод хүрч чадах эсэхийг тооцон судалдаг шалгуур үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн зохицуулалт болон арга хэмжээнүүд нь хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэх боломжтой байна уу? гэдгийг тооцоход ашиглана.

2.4. "Практикт хэрэгжих боломж" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь дагаж мөрдөх болон хэрэгжих боломжтой байгаа эсэхийг шалгана. Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд боломж хир байна, хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх, тэдгээр

хэрэгжүүлэгч субъектэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ байгаа эсэхийг тооцно.

2.5. "Ойлгомжтой байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана.

2.6. "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төсөл нь иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд /хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд/ хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Аливаа хуулийн төслийн зохицуулалт нь тодорхой хүмүүсийн эрх ашигт нөлөөлдөг. Иймд тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана.

2.7. "Зардал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, эсхүл хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд ямар зардал үүсэх, зардлын улмаас үүсэх үр дагавар нь ямар байх зэргийг тооцон судална.

2.8. "Харилцан уялдаа" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг шалгана.

2.9. Шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо тухайн боловсруулж буй хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно.

Жишээ:

Өмгөөллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг урьдчилан тооцох даалгаврын хүрээнд шалгуур үзүүлэлтээ тогтоохдоо дээр дурдсан шалгуур үзүүлэлтүүдээс "хүлээн зөвшөөрөгдөх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгож авъя. Өөрөөр хэлбэл уг хуулийн төслийн үр нөлөөг "хүлээн зөвшөөрөгдөх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд урьдчилан тооцно гэж үзье.

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоох

3.1. Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоох нь энэхүү аргачлалын 2.2 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлттэй салшгүй холбоотой. Хуулийн төслийн бүх зүйл, заалтын үр нөлөөг тооцох нь ихээхэн цаг хугацаа, зардал шаардсан ажил байдаг бөгөөд ихэнх тохиолдолд хуулийн төслийг бүхэлд нь үр нөлөөг шалгах шаардлагагүй байдаг. Иймд хуулийн төслийн тодорхой зүйл, заалтыг сонгон авч үр нөлөөг нь тооцох нь зүйтэй. Тухайлбал, хуулийн төслийг “зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг нь тооцох бол тухайн хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл, түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтуудыг сонгож авна.

3.2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоохдоо шууд үр дагавар үүсгэж байгаа гол ач холбогдолтой заалтуудыг олж тогтоох бөгөөд тухайн заалт, зохицуулалт нь бодитой судалгаа хийж болохуйц байх шаардлагатай. Тухайлбал, хуулийн төсөлд улсын төсвөөс болон иргэн, аж ахуйн нэгжээс тодорхой зардал гарахыг шаардаж байгаа, эсхүл ямар нэг ачаалал үүсгэж байгаа заалт тусгагдсан байвал тэдгээр заалтыг зайлшгүй сонгож үр нөлөөг тооцох шаардлагатай.

3.3. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг шалгах тохиолдолд хуулийн төслийн тодорхой зүйл, заалтыг бус хуулийн төслийг бүхэлд нь шалгана. Учир нь “харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн бусад хуультай нийцэх байдлыг шалгадаг.

Жишээ:

Өмгөөллийн тухай хуулийн төслийг боловсруулж буй нэг зорилго нь өмгөөлөгч нарын мэдлэг, ур чадвар, сахилга хариуцлагыг дээшлүүлэх гэж үзэн Өмгөөллийн тухай хуульд Монголын өмгөөлөгчдийн холбооноос жил бүр өмгөөлөгч нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх болон ёс зүйн сургалтыг зохион байгуулахаар, мөн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан өмгөөлөгч бүр энэ сургалтанд хамрагдах үүрэгтэй байхаар зохицуулалтыг тусгасан гэж үзье.

ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ
/шинэчилсэн найруулга/

5 дугаар зүйл. Монголын өмгөөлөгчдийн холбоо

5.4.Холбоо өмгөөлөгчдөд зориулан давтан болон ёс зүйн сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

16 дугаар зүйл. Өмгөөлөгчийн бүрэн эрх

16.3.Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

16.3.11.хууль зүйн давтан болон ёс зүйн сургалтад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх;

Иймд хуулийн төслөөс “5.4, 16.3.11” гэсэн заалтуудыг үр нөлөөг тооцох хэсгээ болгон сонгож авлаа.

Дөрөв. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг тооцох

4.1. Энэ үе шатанд 2.2 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлтээс урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг тооцно.

4.2. Шалгах хэрэгсэл нь шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байна. Дор дурьдсан хүснэгтэд хуулийн төслийн үр нөлөөг тооцохоор сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг үзүүлэв.

№	Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Практикт турших

3	Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
5	Зардал	Зардлын тооцоо хийх
6	Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Жишээ:

Шалгуур үзүүлэлт, мөн Өмгөөллийн хуулийн төслийн 2 заалтыг шалгах хэсгээ болгон сонгосон байгаа учраас шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг авч үзье.

Шалгуур үзүүлэлт: “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”

Үр нөлөөг тооцох хэсэг:

5.4. Холбоо өмгөөлөгчдөд зориулан давтан болон ёс зүйн сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

16.3.11. Өмгөөлөгч нь хууль зүйн давтан болон ёс зүйн сургалтанд хамрагдаж мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх үүрэгтэй. гэсэн заалтууд

Шалгах хэрэгсэл: “Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх”

4.3. Шалгах хэрэгслийг хэрэглэж үр нөлөөг тооцохын өмнө хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцохоор сонгосон хэсгийн зохицуулалтад хамаарах зүйлсийг тогтоож, түүнтэй болон тухайн зохицуулалттай холбоотой мэдээлэл, статистик тоо баримтыг цуглуулна.

4.4. Шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн үр нөлөөг яаж үнэлэх вэ гэдгийг тогтооно.

4.5. “Зорилгод дүн шинжилгээ хийх” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээ нь тухайн хуулийн төсөлд тавьсан зорилгыг биелүүлэхэд чиглэгдсэн эсэх, зорилгод хүрэх байдал ямар байна гэдэгт дүн шинжилгээ хийх бөгөөд дараахь зүйлийг анхаарна:

4.5.1. дүн шинжилгээ хийхдээ салбарын мэргэжилтнүүдтэй уулзалт, зөвлөгөөн хийх, тухайн асуудалтай холбоотой ном, хэвлэл, судалгааны материал зэргийг ашиглана.

4.5.2. хэрвээ хуулийн төсөлд зорилгод хүрэхэд чиглэсэн хэд хэдэн зохицуулалт, арга хэмжээг тусгасан бол арга хэмжээ, зохицуулалт бүрт дүн шинжилгээ хийж, тэдгээрийн зорилгод хүрэх боломжийг харьцуулна.

4.5.3. хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон зорилго, түүнийг батлан гаргах хэрэгцээ шаардлагыг ямар байдлаар тодорхойлсон, энэ нь хуулийн төсөлд хэрхэн тусгагдсан талаар харьцуулан бичиж, тухайн зохицуулалт, арга хэмжээ нь зорилгод хүрэх боломжтой байна уу, хуулийн төсөлд боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байна уу гэдэгт дүн шинжилгээ хийж харьцуулна.

4.6. "Хуулийн төслийг практикт турших" гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалттай холбоотой тодорхой тохиолдлыг бий болгож, тухайн хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээг холбогдох байгууллага, этгээдийг оролцуулан туршиж үзнэ.

4.6.1. хуулийн төслийг практикт турших нь тухайн хуулийн төсөл хэрэгжих боломжтой байна уу, хуулийг хэрэгжүүлэх байгууллагууд түүнийг хүлээн зөвшөөрч байна уу, бусад этгээдэд хэрхэн нөлөөлж байгаа болон тухайн зохицуулалтын хийдэл, зөрчлийг тогтооход чухал ач холбогдолтой. Гэвч практикт туршилт хийх нь ихээхэн цаг хугацаа, хүн хүч, зардал шаарддаг тул тухайн хуулийн төслийн зохицуулалтыг турших байгууллага байна уу, туршилтанд оролцох этгээд нь хэн байх вэ гэдгийг тогтоож, тэдгээр байгууллага, этгээд туршилтанд оролцохыг зөвшөөрсөн тохиолдолд туршилтын ажиллагааг явуулах нь зүйтэй.

4.6.2. хэрвээ туршилтын ажиллагаа явуулах нь маш их хүн хүч, зардал шаардаж, мөн тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллага, холбогдох этгээд нь туршилтанд оролцохыг зөвшөөрөөгүй тохиолдолд туршилтын ажиллагаа явуулахаас зайлсхийж, тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллага, этгээдээс санал авах замаар энэ шалгах хэрэгслийг хэрэглэж үр нөлөөг тооцно.

4.7. "Ойлгомжтой байдлыг нягтлах" гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт нь хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томъёологдсон эсэхийг шалгаж тогтооно. Үүнд:

4.7.1. тухайн хуулийн төсөлд хамаарах байгууллага, албан тушаалтан, мэргэжлийн холбоо, иргэнээс хуулийн төсөлд санал авч хуулийн төсөл, түүний зүйл, заалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх;

хүрэхэд чиглэсэн хэд хэдэн а хэмжээ, зохицуулалт бүрт гэрэх боломжийг харьцуулна.

хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг ямар лд хэрхэн тусгагдсан талаар а хэмжээ нь зорилгод хүрэх өвсруулах болсон үндэслэл, жилгээ хийж харьцуулна.

" гэсэн шалгах хэрэгслийн боотой тодорхой тохиолдлыг н зохицуулалт, арга хэмжээг н туршиж үзнэ.

х нь тухайн хуулийн төсөл сэрэгжүүлэх байгууллагууд этгээдэд хэрхэн нөлөөлж өрчлийг тогтооход чухал ач нь ихээхэн цаг хугацаа, хүн шийн зохицуулалтыг турших этгээд нь хэн байх вэ гэдгийг анд оролцохыг зөвшөөрсөн ь зүйтэй.

ах нь маш их хүн хүч, зардал длэх байгууллага, холбогдох үй тохиолдолд туршилтын шийн төслийг хэрэгжүүлэх шалгах хэрэгслийг хэрэглэж

шалгах хэрэгслийн хүрээнд шийг хэрэгжүүлэх, хэрэглэх шалгаж тогтооно. Үүнд:

гууллага, албан тушаалтан, санал авч хуулийн төсөл, лэх боломжтой байгаа эсэх;

4.7.2. хуулийн төслийг боловсруулахдаа "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ыг баримталсан эсэх.

4.8. "Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх" гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд тухайн хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн нэгж байгууллагад ачаалал, хүндрэл үүсгэх, эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зэрэг зохицуулалт байгаа тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийнэ.

4.8.1. хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд, мэргэжлийн холбооноос санал авах, санал асуулга явуулах, холбогдох байгууллага, этгээдийн хүрээнд ярилцлага, хэлэлцүүлэг явуулах зэргээр хуулийн төслийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг судална.

4.8.2. мөн хуулийн төслийн үр нөлөөг тооцохдоо практикт турших ажиллагаа явуулсан тохиолдолд туршилтанд оролцсон этгээд тухайн зохицуулалтыг хэрхэн хүлээн авч байгааг судалж, хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгааг хийж болно.

4.9. "Зардлын тооцоо хийх" гэсэн шалгах хэрэгслээр тухайн хуулийн төсөл нь хуулийг хэрэгжүүлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, улсын төсөвт ямар зардал, ачаалал үүсгэж байгааг тооцож, хэрэгжүүлэх субьектэд зардал, ачаалал бага үүсгэх зохицуулалтын хувилбарыг боловсруулах юм.

4.9.1. хуулийн төслийн улмаас хаана, хэнд, хэдий хэмжээний зардал үүсч байна гэдгийг нарийвчлан тооцох шаардлагатай бөгөөд үүнийг "Хуулийн төслийн зардлыг тооцоолох аргачлал"-ын дагуу тооцоолно.

4.10. "Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах" гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах бөгөөд энэ хүрээнд дараахь асуудлыг тогтооно. Үүнд:

4.10.1. хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;

4.10.2. хуулийн төслийн "хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;

4.10.3. хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;

4.10.4. хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;

4.10.5. хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх

4.10.6. хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;

4.10.7. хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;

4.10.8. хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;

4.10.9. татварынхаас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;

4.10.10. тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх;

4.10.11. хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;

4.10.12. шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх;

4.10.13. авилга, хүнд сурталыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх;

4.10.14. хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Жишээ:

Үр нөлөөг тоо замаар үр нөлөө

1. Монголын мэргэжил дээшлү

Энэхүү зохиц зорилгоор Монго

МӨХ-ноос ирү хуульд заасны д байгаа бөгөөд уг Холбоо давхарду

2. Өмгөөлөгч х байх үүрэгтэй. Э судлах зорилгоо боловсруулж, сан

Одоо Монгол өмгөөлөгч өмгөөл нь нийслэлд, 189

Санал асуулга өмгөөлөгчдийн зө санал асуулгын ху асуулгын хуудсыг

Санал асуулгад оролцож дараахь

Санал асуулга

1. Боловсрол: ...

2. Төгссөн сургу

3. Өмгөөлөгчөөс

4. Өмгөөллийн ү мэргэжлийн чиглэ давхардсан бол ям

Жишээ:

Үр нөлөөг тооцох 2 заалт тус бүр дээрээ шалгах хэрэгслийг хэрэглэх замаар үр нөлөөг нь тооцъё.

1. Монголын өмгөөлөгчдийн холбоо өмгөөлөгч нарт зориулсан нэргэжил дээшлүүлэх болон ёс зүйн сургалтыг жил бүр зохион байгуулна.

Энэхүү зохицуулалтын хүлээн зөвшөөрөгдөх байдлыг судлах зорилгоор Монголын өмгөөлөгчдийн холбооноос санал авъя.

МЭХ-ноос ирүүлсэн саналдаа “Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасны дагуу бүх өмгөөлөгчид давтан сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд уг сургалтанд ёс зүйн хичээл багтаж байгаа. Иймээс Холбоо давхардуулан ийм сургалт явуулах шаардлагагүй” гэжээ.

2. Өмгөөлөгч холбооноос зохион байгуулсан сургалтанд хамрагдаж байх үүрэгтэй. Энэхүү зохицуулалтын хүлээн зөвшөөрөгдөх байдлыг судлах зорилгоор өмгөөлөгч нарын дунд санал асуулгын хуудас бэлдэсруулж, санал асуулга явуулсан.

Одоо Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн нийт 1137 өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдний 948 нь нийслэлд, 189 нь орон нутагт байдаг байна.

Санал асуулгыг Монголын өмгөөлөгчдийн холбоо, Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлтэй хамтран явуулсан бөгөөд урьдчилан бэлтгэсэн санал асуулгын хуудсыг өмгөөлөгч нарын цахим хаягаар тарааж санал асуулгын хуудсыг бөглүүлсэн.

Санал асуулгад нийслэлийн 326 өмгөөлөгч, орон нутгаас 33 өмгөөлөгч оролцож дараахь санал асуулгын хуудсыг бөглөж хариуг ирүүлсэн.

Санал асуулга. Өмгөөлөгчдийг сургалтанд хамруулах талаар

1. Боловсрол:

2. Төгссөн сургууль:

3. Өмгөөлөгчөөр ажилласан хугацаа:

4. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш нэргэжлийн чиглэлээр ямар нэг сургалтанд хамрагдаж байсан эсэх? Хамрагдсан бол ямар чиглэлийн сургалтанд хамрагдаж байсан бэ?

А.Тийм.
Б. Үгүй.

5.Өмгөөлөгч нарыг мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх сургалтанд хамруулах шаардлагатай эсэх?

А.Тийм
Б.Үгүй

6.Өмгөөлөгч нарт зориулсан сургалтыг ямар чиглэлээр явуулах нь зүйтэй гэж үзэж байна?

А.Ёс зүйн сургалт
Б.Тодорхой салбар эрх зүйгээр мэргэшүүлэх сургалт
В.Шинээр гарсан хууль тогтоомжийн талаархи сургалт
Г.Гадаад хэлний сургалт

7.Сургалтын хэлбэр ямар байвал илүү зохимжтой вэ?

А.Зайн буюу онлайн хэлбэрийн
Б.Бүсчилсэн сургалт

8.МӨХолбооноос өмгөөлөгч нарт зориулсан сургалтанд хамрагдах боломжтой эсэх?

А.Боломжтой
Б.Боломжгүй

9.Сургалтын хугацаа ямар байвал зохимжтой гэж үзэж байна?

А.Богино хугацааны /1-3 хоног/
Б.Дунд хугацааны /7-14 хоног/
В.Урт хугацааны /1 сар/

10.Сургалтын давтамж ямар байвал зохимжтой вэ?

А.Жилд 1 удаа
Б.2 жилд 1 удаа
В.Хагас жил тутам

11.Өмгөөлөгч нарыг сургалтанд идэвхтэй хамруулахын тулд ямар арга хэмжээ авах нь зүйтэй гэж бодож байна?

А.Төлбөргүй
Б.Тогтмол х
бий болгох
В.Өмгөөлөгч

12.Өмгөөлөгч
Бичнэ үү.

5.1. Үр дүнг үр

5.1.1. шалт

5.1.2. үнэлт

5.1.3. зөвлө

5.2. Үр дүнг үр

гарсан мэдээлэл

санал зэрэг холб

төслийн үр нөл

төслийн үр нөл

үндэстэл болох

лавсралт болно.

5.3. Үр дүнг үр

явцад хуулийн

явцад үр дүн га

хуулийн төсли

туршилтад ор

явцад байсан та

хэрэглээд ямар

хүдэсн зөвшөөр

дүн зэргийг нэг

гэж үзсэн, хүлэ

баримтжуулах

ажиллагааны я

төслийн /эсхүл

хуулийн төсөл б

гэсэн агуулгата

- А.Төлбөргүй сургалт зохион байгуулах
- Б.Тогтмол хамруулахын тулд тодорхой урамшууллын арга хэлбэр бий болгох
- В.Өмгөөлөгч нарт үүрэг болгох

12.Өмгөөлөгч нарыг сургалтанд хамруулах талаар нэмэлт саналаа бичнэ үү.

Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх

5.1. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шат нь дараахь дарааллаар явагдана:

- 5.1.1. шалгах хэрэгслийг хэрэглэсэн үр дүнг баримтжуулах;
- 5.1.2. үнэлэх;
- 5.1.3. зөвлөмж өгөх.

5.2. Үр дүнг баримтжуулах гэдэг нь шалгах хэрэгслийг хэрэглэх явцад гарсан мэдээлэл, тоо баримт, дүгнэлт, оролцогчид, мэргэжлийн холбооны санал зэрэг холбогдох бүх баримтыг цуглуулах ажиллагаа бөгөөд хуулийн төслийн үр нөлөөг тооцох явц бүрийг баримтжуулна. Энэ нь хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнг зөв үнэлэх, зөвлөмж өгөх үндэслэл болох бөгөөд цуглуулсан бүх баримт, мэдээлэл нь зөвлөмжийн хэвсгалт болно.

5.3. Үр дүнг үнэлэх нь шалгах хэрэгслийг хэрэглэж, үр нөлөөг тооцох явцад хуулийн төслийн /эсхүл түүний тодорхой зохицуулалтын/ улмаас ямар үр дүн гарсныг үнэлж, дүгнэлт бичих ажиллагаа юм. Тухайлбал, хуулийн төслийг практикт туршиж үзэх ажиллагааны үед тухайн туршилтанд оролцогчдоос гарсан санал, тэднээс туршилтанд ороход ямар байсан талаар болон мөн туршилтын явцад хуулийн зохицуулалтыг хэрэглэхэд ямар нэг хүндрэл гарч байсан эсэх талаар өгсөн тайлбар, мөн хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийхэд авсан санал асуулгын үр дүн зэргийг нэгтгэн, оролцогчид тухайн хуулийн төсөл, зохицуулалтыг юу гэж үзсэн, хүлээж авсан эсэхийг үнэлж, дүгнэлт бичнэ. Өөрөөр хэлбэл, баримтжуулах шатанд цуглуулсан баримт, мэдээлэл, үр нөлөөг тооцох ажиллагааны явц, тэдгээрийн үр дүнг үнэлсний үндсэн дээр хуулийн төслийн /эсхүл тодорхой зүйл, заалтын/ үр нөлөөг тооцоход тухайн хуулийн төсөл батлагдснаар ийм ийм үр нөлөө, үр дагавар гарахаар байна гэсэн агуулгатай дүгнэлтийг бичнэ.

5.4. Үнэлгээ өгөхдөө оролцогчдын хэдэн хувь нь юу гэж үзсэн гэх мэтээр тоон үзүүлэлтээр үнэлж болно.

5.5. Хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан тухайн хуулийн төслийг өөрчлөх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөхгүй хэвээр нь үлдээх талаар зөвлөмж бичнэ. Тухайлбал, хуулийн төслийн үр нөлөөг тооцоход хуулийн төсөл батлагдснаар зорилгодоо хүрэх байдал нь эерэг, тухайн зохицуулалт нь дагаж мөрдөх, хэрэгжих боломжтой, хуулийн төслийг хэрэглэх, хэрэгжүүлэх байгууллага нь түүнийг хүлээн зөвшөөрч байгаа гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд хуулийн төсөл яг ийм байдлаараа батлагдах нь үр дүнтэй байна гэсэн зөвлөмжийг өгнө.

5.6. Хэрвээ хуулийн төсөл, түүний зохицуулалтыг өөрчлөх, эсхүл нэмэлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмжийг өгч байгаа тохиолдолд үр дүнг үнэлэх шатанд гарсан дүгнэлтийг үндэслэн ямар байдлаар өөрчлөх, нэмэлт оруулах талаар зөвлөмждөө тусгана. Тухайлбал, үр нөлөөг тооцох явцад холбогдох байгууллага, этгээдээс ирүүлсэн санал, хэлэлцүүлэгт оролцсон этгээдээс гарсан санаа, туршилтын ажиллагааны тэмдэглэл зэргийг үндэслэн тэдгээрийн саналыг хуулийн төсөлд аль болох тусгах замаар дагаж мөрдөх болон хэрэгжүүлэх боломжтой, бага зардал, ачаалал үүсгэх, хуулийг хэрэгжүүлэгчид илүү ойлгомжтой байх зохицуулалтыг томъёолон зөвлөмжид тусгана.

Жишээ:

Өмгөөллийн тухай хуулиас авсан 2 заалтыг шалгуур үзүүлэлт, шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг нь тооцсоныг үнэлье.

Баримтжуулалт. Өмгөөллийн тухай хуулийн төсөлд шинээр орж буй 2 заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийхдээ Монголын өмгөөлөгчдийн холбооноос бичгээр санал авсан, мөн өмгөөлөгчдөөс урьдчилан бэлтгэсэн маягтын дагуу санал асуулга авсан.

Иймд МӨХ-ноос ирүүлсэн санал, санал асуулгын маягтуудыг нэгтгэн үр дагаврыг урьдчилан тооцох ажиллагааны дүгнэлт, зөвлөмжид хавсаргана.

Үнэлэх. Одоо энэ ша
авсан санал асуулгын д

1. МӨХ ирүүлсэн са
Хуульч сонгон шалгару
байгаа тул уг зохицуула

2. Өмгөөлөгч нараас

Санал асуулгад ни
хариултыг нэгтгэн хару

3. Өмгөөлөгчөөр аж

4. Өмгөөллийн үйл а
мэргэжлийн чиглэлээр
Хамрагдсан бол ямар ч

А.Тийм 65 /эрүүт
Б.Үгүй 294

5. Өмгөөлөгч нары
хажруулах шаардлагат

А.Тийм 330
Б.Үгүй 29

6. Өмгөөлөгч нарт
зүйтэй гэж үзэж байна

А.Ес зүйн сургалт
Б.Тодорхой салб
В.Шинээр гарсан
Г.Гадаад хэлний

7. Сургалтын хэлбэ

А.Зайн буюу онл
Б.Бүсчилсэн сур
В.Танхимын – 20

нь нь юу гэж үзсэн гэх мэтээр

киллагааны үр дүнд гарсан
г өөрчлөх, нэмэлт оруулах,
өвлөмж бичнэ. Тухайлбал,
лийн төсөл батлагдснаар
ицуулалт нь дагаж мөрдөх,
х, хэрэгжүүлэх байгууллага
үгнэлт гарсан тохиолдолд
нь үр дүнтэй байна гэсэн

лтыг өөрчлөх, эсхүл нэмэлт
айгаа тохиолдолд үр дүнг
байдлаар өөрчлөх, нэмэлт
л, үр нөлөөг тооцох явцад
ал, хэлэлцүүлэгт оролцсон
гааны тэмдэглэл зэргийг
аль болох тусгах замаар
ага зардал, ачаалал үүсгэх,
зохицуулалтыг томъёолон

шалгуур үзүүлэлт, шалгах
е.

н төсөлд шинээр орж буй
алгаа хийхдээ Монголын
сан, мөн өмгөөлөгчдөөс
лга авсан.

лгын маягуудыг нэгтгэн
ы дүгнэлт, зөвлөмжид

Үнэлэх. Одоо энэ шатанд МӨХ-ноос ирүүлсэн санал, өмгөөлөгчдөөс авсан санал асуулгын дүнг үнэлж, дүгнэлтээ бичье.

1. МӨХ ирүүлсэн саналдаа “өмгөөлөгч нарт зориулсан сургалт нь Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасан сургалттай давхцаж байгаа тул уг зохицуулалтыг шаардлагагүй гэж үзэж байна.” гэжээ.

2. Өмгөөлөгч нараас авсан санал асуулгын үр дүнг нэгтгэн үнэлье.

Санал асуулгад нийт 359 өмгөөлөгч оролцсон бөгөөд тэдний хариултыг нэгтгэн харуулбал:

3. Өмгөөлөгчөөр ажилласан хугацаа: 7-с дээш жил-91
3-5 жил -197
1-3 жил -71

4. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш мэргэжлийн чиглэлээр ямар нэг сургалтанд хамрагдаж байсан эсэх? Хамрагдсан бол ямар чиглэлийн сургалтанд хамрагдаж байсан бэ?

А.Тийм 65 /эрүүгийн эрх зүйн, иргэний эрх зүйн чиглэлээр/
Б.Үгүй 294

5. Өмгөөлөгч нарыг мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх сургалтанд хамруулах шаардлагатай эсэх?

А.Тийм 330
Б.Үгүй 29

6. Өмгөөлөгч нарт зориулсан сургалтыг ямар чиглэлээр явуулах нь зүйтэй гэж үзэж байна?

А.Ёс зүйн сургалт - 55
Б.Тодорхой салбар эрх зүйгээр мэргэшүүлэх сургалт - 89
В.Шинээр гарсан хууль тогтоомжийн талаархи сургалт - 210
Г.Гадаад хэлний сургалт 5

7. Сургалтын хэлбэр ямар байвал илүү зохимжтой вэ?

А.Зайн буюу онлайн хэлбэрийн - 137
Б.Бүсчилсэн сургалт - 22
В.Танхимын – 200

8. МӨХолбооноос өмгөөлөгч нарт зориулсан сургалтанд хамрагдах боломжтой эсэх?

- А.Боломжтой - 359
- Б.Боломжгүй – 0

9. Сургалтын хугацаа ямар байвал зохимжтой гэж үзэж байна?

- А.Богино хугацааны /1-3 хоног/ -325
- Б.Дунд хугацааны /7-14 хоног/ - 24
- В.Урт хугацааны /1 сар/

10. Сургалтын давтамж ямар байвал зохимжтой вэ?

- А.Жилд 1 удаа - 270
- Б.2 жилд 1 удаа - 89
- В.Хагас жил тутам

11. Өмгөөлөгч нарыг сургалтанд идэвхтэй хамруулахын тулд ямар арга хэмжээ авах нь зүйтэй гэж бодож байна?

- А.Төлбөргүй сургалт зохион байгуулах - 256
- Б.Тогтмол хамруулахын тулд тодорхой урамшууллын арга хэлбэр бий болгох - 78
- В.Өмгөөлөгч нарт үүрэг болгох – 25

12. Өмгөөлөгч нарыг сургалтанд хамруулах талаар нэмэлт саналаа бичнэ үү.

Сургалт зохион байгуулах тохиолдолд аль болох олон өмгөөлөгчийг хамруулах, сургалтыг чиглэл, чиглэлээр тогтмол зохион байгуулах, хүссэн сургалтандаа оролцох боломжийг өмгөөлөгч нарт олгох, сургалтыг чанартай зохион байгуулах зэрэг саналуудыг нэмэлтээр бичсэн байна.

Санал асуулгын дүнгээс үзэхэд өмгөөлөгч нарт зориулсан сургалт зайлшгүй хэрэгтэй байгаа бөгөөд сургалтыг аль болох богино хугацаатайгаар төлбөргүй, мөн Монголын өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулбал сургалтанд хамрагдах боломжтой гэж санал асуулгад оролцсон өмгөөлөгч нарын ихэнх нь үзжээ.

“Мөн өмгөөлөгч нараас авсан санал асуулгын үр дүнг аль болох ойлгомжтой харагдах байдлаар хүснэгтлэн харуулж болно.”

Дүгнэлт: Өмгөөл хуулийг хэрэгжүүлэ байгаа боловч хүлээ үндэслэлтэй бус бай тухай хуульд зааса боловч Хуульч сонг нь нийт хуульчдад ; өмгөөлөгчийн мэрг дээшлүүлэхэд сайн

Түүнчлэн өмгөөл нарт зориулсан сур тарлийн сургалтад боломжтой гэж үзэ

Зөвлөмж: Хуу лульд нэмэлт, өө үйл ажиллагаанд т Судалгаанаас үз нөлөөлж чаддаггүй дээр ихээхэн догол учраас өмгөөлүүлэ байр суурь, эрх х өмгөөлөгчдийн мэрг оруулсан.

Хуулийн төслий зорицуулалтыг ша зохион байгуулалт, байгуулах нь түүн

Мөн үр нөлөөг н лтээд болох өмгөө өмгөөлөгч нарыг н Өмгөөлөгчдийн хол орсон.

Иймд хуулийн тө нарт зориулсан мэ бүр зохион байгуу сургалтанд хамра боломжтой, хэрэгж дээрхи заалтыг хэв

сургалтанд хамрагдах

ий гэж үзэж байна?

той вэ?

хамруулахын тулд ямар

56

амшууллын арга хэлбэр

к талаар нэмэлт саналаа

болох олон өмгөөлөгчийг
тмол зохион байгуулах,
өмгөөлөгч нарт олгох,
г саналуудыг нэмэлтээр

н нарт зориулсан сургалт
тыг аль болох богино
мгөөлөгчдийн холбооноос
мжтой гэж санал асуулгад

улгын үр дүнг аль болох
руулж болно."

Дүгнэлт: Өмгөөллийн тухай хуульд шинээр орж буй энэхүү 2 заалтыг хуулийг хэрэгжүүлэгчид буюу МӨХолбооноос шаардлагагүй гэж үзэж байгаа боловч хүлээн зөвшөөрөх боломжгүй байгаа шалтгаан нь төдийлэн үндэслэлтэй бус байна. Өөрөөр хэлбэл, МӨХ Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасан сургалттай давхцсан тул шаардлагагүй гэж байгаа боловч Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасан дээрхи сургалт нь нийт хуульчдад зориулсан сургалт байдаг. Иймээс энэхүү сургалтаар өмгөөлөгчийн мэргэжлийн үр чадвар, мэдлэг боловсрол, ёс зүйг дээшлүүлэхэд сайн нөлөөлөхгүй гэж үзэж байна.

Түүнчлэн өмгөөлөгч нараас авсан санал асуулгын дүнгээр өмгөөлөгч нарт зориулсан сургалт тэр бүр зохион байгуулагддаггүй, цаашид ийм төрлийн сургалтанд хамрагдах шаардлагатай, өмгөөлөгч нар оролцох боломжтой гэж үзсэн.

Зөвлөмж: Хуулийн төслийг боловсруулахдаа Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх, өмгөөллийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар судалгаа хийсэн. Судалгаанаас үзэхэд иргэд өмгөөлөгчдийг шүүхийн шийдвэрт нөлөөлж чаддаггүй, мэдлэг, үр чадвар муугаас гадна ёс зүйн тал дээр ихээхэн доголдолтой, өмгөөллийн үйлчилгээний хөлс хэт өндөр учраас өмгөөлүүлэх эрхээ эдэлж чаддаггүй гэх мэтээр өмгөөлөгчдийн байр суурь, эрх хэмжээний талаар хангалтгүй дүгнэлт өгсөн учраас өмгөөлөгчдийн мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх зорилгоор 2 заалтыг оруулсан.

Хуулийн төслийг хэрэгжүүлэгч байгууллага болох МӨХолбоо үг зохицуулалтыг шаардлагагүй гэж үзсэн. Гэвч МӨХолбооны бүтэц, зохион байгуулалт, чиг үүргээс үзэхэд төсөлд заасан сургалтыг зохион байгуулах нь түүний үндсэн чиг үүрэгт нийцэхээр байна.

Мөн үр нөлөөг нь тооцсон зохицуулалтын үр дагаврыг шууд хүртэх эгтгээд болох өмгөөлөгч нар сургалтанд оролцох боломжтой, сургалтыг өмгөөлөгч нарыг нэгтгэсэн, мэргэжлийн байгууллага болох Монголын Өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулах нь илүү үр дүнтэй гэж үзсэн.

Иймд хуулийн төслийн "Монголын өмгөөлөгчдийн холбоо өмгөөлөгч нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх болон ёс зүйн сургалтыг жил бүр зохион байгуулна", "Өмгөөлөгч Холбооноос зохион байгуулсан сургалтанд хамрагдаж байх үүрэгтэй" гэсэн заалтууд нь хэрэгжих боломжтой, хэрэгжүүлэх байгууллагын чиг үүрэгт нийцэхээр байгаа тул дээрхи заалтыг хэвээр үлдээх нь зүйтэй гэсэн зөвлөмжийг өгч байна.